

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 492 ДУГААР ТОГТООЛООР
БАТЛАГДСАН “МАХ” ХӨТӨЛБӨРИЙН 2016-2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2016 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	МУ-ын Засгийн газрын 492 дугаар тогтоол “Мах” хөтөлбөр	Төслийн зорилго: Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”, “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2015 оны 108 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах, улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзлийг тогтворжуулах зорилгоор махны нөөц бүрдүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэхийн тулд мал бэлтгэж төхөөрдөг, мах боловсруулдаг болон зоорь бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид зээл олгох, дэмжлэг үзүүлэх.			
2	Санхүүгийн эх үүсвэр	Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэр			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/Хэрэгжих хугацаа	Гол хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ 2016-2017 он. 2 жилийн хугацаатай.			
4	Төсөл, хөтөлбөрийн үр дүн	<p><i>Төслийн гол үр дүн:</i> Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах, улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзлийг тогтворжуулах.</p> <p>Үр дүн 1: Махны хангамж, нийлүүлэлт сайжирч, малчдын орлого нэмэгдэнэ.</p> <p>Үр дүн 2: Мах, махан бүтээгдэхүүний экспорт өсч, гадаад валютын эх үүсвэр нэмэгдэнэ.</p> <p>Үр дүн 3: Мах, махан бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал хангагдаж улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзэл буурна.</p> <p>Үр дүн 4: Дотоодын мах бэлтгэл, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, ажлын байр шинээр бий болно.</p>			
5	Зардал багц 1	Төсөв (нийт шаардагдах зардал)	100.0 тэрбум төгрөг (дотоодын хэрэгцээний махны нөөц бүрдүүлэхэд 25.0 тэрбум, мах экспортлоход 75.0 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг)		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Дотоодын хэрэгцээний махны нөөц бүрдүүлэх	2016 он	11.8 тэрбум төг	47.2 %
			2017 он	13.2 тэрбум төг	52.8 %
Нийт зардал			25.0 тэрбум төг	100.0 %	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа:	Үйл ажиллагааны биелэлт:			
<i>1-р үр дүнгийн хүрээнд:</i> Махны хангамж, нийлүүлэлт сайжирч, малчдын орлого нэмэгдэнэ.					
7	<i>Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.2.1</i> Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;	<p>1. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”, “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2015 оны 108 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 492 дугаар тогтоолоор “Мах” хөтөлбөрийг батлуулсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 16 дугаар тогтоолоор “Мах” хөтөлбөрийн хүрээнд дамжуулан олгох зээлийн хэмжээг нийт 100 тэрбум төгрөг байхаар баталсан.</p> <p>2. “Мах” хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд Улаанбаатар,</p>			

		Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2016-2018 оны 3-7 дугаар сарын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр мах нийлүүлэхэд 25 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсэн. ХШҮ- 70%
<i>2-р үр дүнгийн хүрээнд:</i> Мах, махан бүтээгдэхүүний экспорт өсч, гадаад валютын эх үүсвэр нэмэгдэнэ.		
8	<i>Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.2.2</i> Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн импортоор авах сонирхол бүхий оронтой мах, махан бүтээгдэхүүний олон улсын худалдааны гэрээ, хэлцэл хийж, ариун цэвэр, хорио цээрийн нөхцөл, шаардлагын талаар харилцан тохиролцож, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	1.2015 оны 11 сард “Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн тухай” протоколд гарын үсэг зурсан. БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын Бүртгэл, гэрчилгээжүүлэлтийн газраас дулааны аргаар боловсруулсан үхэр, хонины мах, махан бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортолж зөвшөөрлийг Мах маркет, Монгол эко мах ХХК, “Хүн-Од” ХХК, “Хатан сүйх” ХХК-д олгосон . 2. 2016 оны 01 дүгээр сард “Үхэр, хонь, ямааны мах экспортолж үеийн мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагын тухай протокол”-ыг үзэглэсэн. 2016 оны 01 сарын 18-ны өдөр “Үхэр, хонь, ямааны махны мал эмнэлгийн гэрчилгээ”-ний загварыг БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газарт явуулж баталгаажуулсан. БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын Гэрчилгээ, бүртгэлжүүлэлтийн газраас Завхан аймгийн “Завхан хүнс групп” ХХК, “Бумномин” ХХК, “Тэс шим” ХХК, “ЭДГС” ХХК, Хөвсгөл аймгийн “Хөвсгөл мах маркет” ХХК (Монгол эко мах ХХК), Увс аймгийн “Мон-тува” ХХК (Грийн грэйс лэнд)-ийн махны үйлдвэрүүдэд бэлтгэсэн үхэр, хонь, ямааны махыг экспортолж зөвшөөрлийг тус тус олгосон. ХШҮ-100%
<i>3-р үр дүнгийн хүрээнд:</i> Мах, махан бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал хангагдаж улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзэл буурна.		
9	<i>Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.2.3.</i> Хөтөлбөрт оролцогч хуулийн этгээд, арилжааны банкиг сонгон шалгаруулах;	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор батлагдсан “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-38 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр мах нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулсан. “Мах” хөтөлбөрийн хүрээнд зээлийн дэмжлэг үзүүлэх сонгон шалгаруулалтад 37 аж ахуйн нэгж материал ирүүлснийг ажлын хэсэг үнэлж, 26 аж ахуйн нэгжийг шалгаруулж, “МХ16/02/25 урилгын дагуу Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр мах нийлүүлэх сонгон шалгаруулалтын шаардлагад нийцсэн аж ахуйн нэгжийн жагсаалт”-ыг 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 01/727 тоот албан бичгээр, Монгол Улсын Хөгжлийн банкинд, 2016 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 01/815 тоот албан бичгээр арилжааны банкинд тус тус хүргүүлсэн. ХШҮ- 100%

<p>Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.2.5. Зах зээлд нийлүүлж байгаа махны үнэ, хангамжийн тогтвортой байдлыг хангах;</p>		Техникийн шаардлага хангасан 26 аж ахуйн нэгжийн дундаж үнэ, төг/кг	2016.05.18-ны өдрийн махны зах зээлийн дундаж үнэ, төг/кг	2016 онд нөөцөлсөн махыг борлуулах үнэ, төг/кг	Зах зээлийн дундаж үнэ ба борлуулах үнийн харьцуулалт, %	
	1	Үхрийн ястай мах	5640	8490	5750	32,3%
	2	Хонины ястай мах	4900	7070	5400	23,6%
	3	Ямааны мах	4000	5305	4400	17,1%

“Мах” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2016 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан нийлүүлэх нөөцөлсөн махны үнийг сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн үнийн дундаж болон махны үнэ хамгийн өндөр байдаг сар буюу өнөөдрийн үнийг харьцуулан гаргасан.

Махны үнэ хамгийн өндөр байдаг 5-р сард махны үнийн өсөлтийг бууруулж, зах зээлийн махны үнээс 17-32 хувийн хямд үнээр махыг хэрэглэгчдэд нийлүүлж, махны зах зээлийн үнийг тогтворжуулсан.

ХШҮ - 100%

4-р үр дүнгийн хүрээнд: Дотоодын мах бэлтгэл, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, ажлын байр шинээр бий болно.

<p>Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.2.4. Дотоодын болон экспортын махны нөөц бүрдүүлэх;</p>	<p>“Мах” хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2016 оны 3-7 дугаар сарын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр мах нийлүүлэх, “2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс өмнө 500 тонноос багагүй хэмжээний махыг бэлтгэн зориулалтын хөргөлттэй агуулахад хадгалсан” аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж, 25 тэрбум төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хаврын улирлын махны нийлүүлэлтийг сайжруулах, үнэ тогтворжуулах зорилгоор ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-38 дугаартай тушаалаар “Мах” хөтөлбөрт оролцох аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, нөөцийн махны бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт болон махны чанар, аюулгүй байдалд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>“Мах” хөтөлбөрийн хүрээнд зээлийн дэмжлэг үзүүлэх сонгон шалгаруулалтад 37 аж ахуйн нэгж материал ирүүлснийг ажлын хэсэг үнэлж сонгон шалгаруулалтын шаардлагад нийцсэн 26 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалт болон холбогдох бусад мэдээллийг 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 01/727 тоот албан бичгээр Монгол Улсын Хөгжлийн банкинд хүргүүлсэн.</p> <p>2016 оны 6 дугаар сарын эхний байдлаар дээрх 26 аж ахуйн нэгжээс арилжааны банкны зээлийн хорооны хурлаар нийт 10 аж ахуйн нэгжид 25.0 (хорин таван тэрбум) төгрөгийн зээл олгох шийдвэр гарсан.</p> <p>Хөгжлийн банкаас 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар арилжааны банкны зээлийн хорооны шийдвэр гарсан 4 аж ахуйн нэгжид зээл олгоод байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Саян-уул ХХК 294,6 сая төгрөг 2016.06.20 Баатрууд тэнгэр ХХК 7.0 тэрбум төгрөг 2016.07.01 Дархан мийт фүүдс ХХК 3.5 тэрбум төгрөг 2016.07.01 Боса импекс ХХК 1.0 тэрбум төгрөг 2016.07.04 <p>НИЙТ 11.8 тэрбум төгрөг</p>
--	---

	<p>Хөтөлбөрийн хүрээнд зээл авсан дээрх 4 аж ахуйн нэгж нь тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу 2016 оны 8-12 дугаар сард нийт 2,360.0 тонн махны нөөцийг бүрдүүлж, 2017 оны хот, суурин газрын хүн амын хаврын улирлын 3-7 дугаар сарын хэрэгцээнд тогтоосон үнээр мах нийлүүлэх үүргийг хүлээсэн болно.</p> <p>ХХААХҮ-ийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А-38 дугаар тушаалаар байгуулагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкаас олгосон зээлийн хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдэд хяналт, шалгалт хийх ажлын хэсэг” 2016 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд зээл авсан “Баатрууд тэнгэр” ХХК, “Боса импекс” ХХК, “Саян-Уул” ХХК, Дархан хотын “Дархан мийт фүүдс” ХХК-ын агуулах дахь нөөцийн мах бүрдүүлэлт, агуулахын үйл ажиллагаа, махны чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, холбогдох баримт бичигт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Баатрууд тэнгэр” ХХК нь тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу нийт 1400 тн махны нөөц бүрдүүлэхээс 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар бүрдүүлбэл зохих махны нөөцийн 7,1% буюу 100 тн мах нөөцөлж хадгалсан байсан. Тус компанийн зүгээс үүнийг “Цас орж, даваа хаагдсаны улмаас хөдөөнөөс мах орж ирэхгүй байна. 12 дугаар сарын 30 гэхэд бүх махны нөөцийг бүрдүүлнэ” гэж тайлбарласан. 2. “Боса импекс” ХХК нь тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу нийт 200 тн махны нөөц бүрдүүлэхээс 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 172 тн мах нөөцөлж хадгалсан нь бүрдүүлбэл зохих махны нөөцийн 86,0% байсан. 3. “Саян-Уул” ХХК нь тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу нийт 60 тн махны нөөц бүрдүүлэхээс 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 57,5 тн мах нөөцөлж хадгалсан нь бүрдүүлбэл зохих махны нөөцийн 97,0% байсан. 4. “Дархан мийт фүүдс” ХХК нь тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу нийт 700 тн махны нөөц бүрдүүлэхээс 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 880.1 тонн махыг агуулахдаа нөөцлөн хадгалж гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна. <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөлжилт хүндэрсэн орон нутгаас мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээ”-г зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор “Мах” хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкны зээлийн хорооны шийдвэр нь гарсан боловч “Хөгжлийн банк”-аас зээл олголт нь хүлээгдэж байсан 6 аж ахуйн нэгжийн зээлийн асуудлыг шийдвэрлэж нийт 13.2 тэрбум төгрөгийн зээлийн хүүний 8 нэгж хувьд хөнгөлөлт олгохоор тус яам Хөгжлийн банктай гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр 6 аж ахуйн нэгжтэй “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэмэлт гэрээ байгуулсан. Гэрээний дагуу өвөлжилт хүндэрсэн орон нутгаас мал, мах бэлтгэж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд нийлүүлж, тогтоосон үнээр мах худалдан борлуулах болно.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолоор өвөлжилт хүндэрч байгаа орон нутгаас мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг мах боловсруулах үйлдвэрүүд, мах хадгалах зориулалтын агуулах бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны төсөвт тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгох урамшууллын зардлаас гарган санхүүжүүлэхийг даалгасан.</p> <p>Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Мах”</p>
--	---

		<p>хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр шийдвэрлэж, арилжааны банкны зээлийн хорооны шийдвэр нь гарсан боловч “Хөгжлийн банк”-аас зээл олголт нь хүлээгдэж байсан 6 аж ахуйн нэгжийн 13.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Үүнд:</p> <table border="0"> <tr> <td>Сүхбаатар мах маркет ХХК</td> <td>Голомт банк</td> <td>2 100 000 000 төг.</td> </tr> <tr> <td>Эй Эн Ди Эм ХХК</td> <td>Голомт банк</td> <td>2 100 000 000 төг.</td> </tr> <tr> <td>Мах импэкс ХК</td> <td>Голомт банк</td> <td>3 800 000 000 төг</td> </tr> <tr> <td>Эрдмийт ХХК</td> <td>Хаан банк</td> <td>2 500 000 000 төг.</td> </tr> <tr> <td>Сайнза интернэшнл ХХК</td> <td>Хаан банк</td> <td>603 600 000 төг.</td> </tr> <tr> <td>ХКҮ ХХК</td> <td>Худалдаа</td> <td>2 100 000 000 төг.</td> </tr> </table> <p style="text-align: right;">Хөгжлийн банк</p> <p>Хөгжлийн банкаас дээрх 6 компанид арилжааны банкаар дамжуулан нийт 13 203 600 000 төгрөгийн зээлийг олгосон бөгөөд зээлийн жилийн хүүний 8 хувийн хөнгөлөлтийн зардлыг тус яамнаас санхүүжүүлэхээр Хөгжлийн банктай гэрээ байгуулсан.</p> <p>Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 6 аж ахуйн нэгж :</p> <ol style="list-style-type: none"> 1. “Сүхбаатар мах маркет” ХХК нь Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгийн өвөлжилт хүндэрсэн сумын малчин болон мал бүхий иргэдээс нийт 525 тн мах; 2. “Сайнза интернэшнл” ХХК нь Булган аймгийн өвөлжилт хүндэрсэн Хангал, Тэшиг, Бугат, Баян агт, Сэлэнгэ, Булган сумын малчин болон мал бүхий иргэдээс нийт 150 тн мах ; 3. “ХКҮ” ХХК нь өвөлжилт хүндэрсэн Баянхонгор аймгийн Баянбулаг, Өвөрхангай аймгийн Есөнзүйл, Нарийнтээл, Хөвсгөл аймгийн Жаргалант, Тосонцэнгэл, Хэнтий аймгийн Батширээт, Цэнхэрмандал сумын малчин болон мал бүхий иргэдээс нийт 525 тн мах; 4. “Эй Эн Ди Эм” ХХК нь өвөлжилт хүндэрсэн Хөвсгөл аймгийн Галт, Шинэ-Идэр, Рэнчинлхүмбэ, Завхан аймгийн Алдархаан, Отгон, Архангай аймгийн Чулуут, Хотонт, Хайрхан сумын малчин болон мал бүхий иргэдээс нийт 525 тонн мах; 5. “Эрдмийт” ХХК нь өвөлжилт хүндэрсэн Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант, Архангай аймгийн Эрдэнэмандал, Цэцэрлэг, Булган аймгийн Хангал, Тэшиг, Бугат, Баян-Агт, Сэлэнгэ, Булган сумдын малчин болон мал бүхий иргэдээс нийт 625 тонн мах; 6. “Мах импэкс” ХХК нь өвөлжилт хүндэрсэн Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Хархорин, Баянгол, Уянга, Бат-Өлзий, Баянгол, Бүрд, Завхан аймгийн Тосонцэнгэл, Тэлмэн, Их-Уул, Нөмрөг, Сонгино, Түдэвтэй, Цагаанхайрхан сумдын малчин болон мал бүхий иргэдээс нийт 950 тонн мах; <p>Дээрх 6 компани нь өвөлжилт хүндэрсэн орон нутгийн малчин болон мал бүхий иргэдээс тус яамтай байгуулсан гэрээний дагуу нийт 3300 тонн махыг бэлтгэж, 2017 оны Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан худалдан борлуулна.</p> <p>“Мах” хөтөлбөрийн хүрээнд оролцогч 10 аж ахуйн нэгж тус бүр 15-20 хүнийг ажиллуулж, нийт 150-200 ажлын байрыг бий болгосон байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ- 70%</p>	Сүхбаатар мах маркет ХХК	Голомт банк	2 100 000 000 төг.	Эй Эн Ди Эм ХХК	Голомт банк	2 100 000 000 төг.	Мах импэкс ХК	Голомт банк	3 800 000 000 төг	Эрдмийт ХХК	Хаан банк	2 500 000 000 төг.	Сайнза интернэшнл ХХК	Хаан банк	603 600 000 төг.	ХКҮ ХХК	Худалдаа	2 100 000 000 төг.
Сүхбаатар мах маркет ХХК	Голомт банк	2 100 000 000 төг.																		
Эй Эн Ди Эм ХХК	Голомт банк	2 100 000 000 төг.																		
Мах импэкс ХК	Голомт банк	3 800 000 000 төг																		
Эрдмийт ХХК	Хаан банк	2 500 000 000 төг.																		
Сайнза интернэшнл ХХК	Хаан банк	603 600 000 төг.																		
ХКҮ ХХК	Худалдаа	2 100 000 000 төг.																		

<p>Дүгнэлт (ололт, анхаарах асуудлууд)</p>	<p>Ололт</p> <p>1. Хөтөлбөрийн хүрээнд махны үнийг тогтворжуулж, хот суурин газрын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд тогтвортой үнээр мах нийлүүлэх, улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзлийг тогтворжуулах нөхцлийг бүрдүүлж байна.</p> <p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь малчдаас мал, мах бэлтгэж малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлж байна.</p> <p>Дутагдал</p> <p>1. Санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлын улмаас хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангах боломжгүй болсон. Хөгжлийн банкны нийт эх үүсвэрийн хуваарилагдаагүй байгаа үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа тул “Мах” хөтөлбөрийн хүрээнд мах экспортлох аж ахуйн нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх 75.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, зээл олгох боломжгүй болсон.</p> <p>Анхаарах асуудал</p> <p>- Мал, мах бэлтгэлийн үеэр буюу 8-11 дүгээр сард мал төхөөрөх үйлдвэр бүхий аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн зээл олгох ажлыг зохион байгуулах нь үр дүнтэй.</p> <p>-Мал төхөөрөх үйлдвэрт мал нядалгааны үеэр эргэлтийн хөрөнгийн богино хугацааны зээл олгосноор махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн боловсруулж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан махыг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.</p> <p>-Мөн үйлдвэрийн аргаар төхөөрсөн малын арьс, нэхий, шир нь гадны ямар нэгэн гэмтэлгүй байдаг тул арьс, шир боловсруулах үйлдвэрийн шаардлагыг хангах давуу талтай.</p>					
<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>Төслийг хэрэгжүүлэгч талууд боллоцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан.</p>					
<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</p>	<p>Биелэлт дундаж</p>	<p>Үр дүнгийн тоо</p>	<p>Үр дүн 1</p>	<p>Үр дүн 2</p>	<p>Үр дүн 3</p>	<p>Үр дүн 4</p>
<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)</p>	<p>87.5</p>	<p>4</p>	<p>70</p>	<p>90</p>	<p>100</p>	<p>90</p>
	<p>Нэгдсэн үнэлгээ</p>					
	<p>..., %</p>					

**ХӨТӨЛБӨРИЙН ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН,
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРСЭН ТҮВШИН**

№	Үр дүн	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үр дүн					Үнэлгээ	
1	Үр дүн 1	Махны хангамж, нийлүүлэлт сайжирч, малчдын орлого нэмэгдэнэ.	Махны нийлүүлэлт, хангамжийн талаарх Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2016 онд малын хэрэглээний зарлага 12,8 хувиар буурсан хэдий ч зах зээлд худалдан борлуулсан малын тоо 2,3 хувиар өссөн дүнтэй байна.					70%	
			№	Үзүүлэлт	2015 он	2016 он	2016/2015		
			1	Малын хэрэглээний зарлага, мян.толгой	14556.7	12700.0	87.2		
			2	Зах зээлд худалдан борлуулсан малын тоо, мян.толгой	6650.9	6803.2	102.3		
2	Үр дүн 2	Мах, махан бүтээгдэхүүний экспорт өсч, гадаад валютын эх үүсвэр нэмэгдэнэ.	Хөтөлбөр хэрэгжих хугацаанд малын махны экспорт 1.9 дахин нэмэгдсэн байна. 2015 оны эхний 12 сарын байдлаар 10 193.6 мянган долларын 4.8 мянган тонн малын мах экспортолсон бол 2016 онд 16858.6 мянган долларын 9,2 мянган тонн мах гаргасан байна. “Мах” хөтөлбөрт оролцогч “Дархан meat фүүдс” ХХК 2016 онд 2900 тн үхэр, адуу, “Эрдмийт” ХХК 600 тонн үхрийн мах ОХУ, БНХАУ-д экспортолсон нь нийт экспортын 38 хувийг эзэлж байна.					90%	
3	Үр дүн 3	Мах, махан бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал хангагдаж улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзэл буурна.	Махны төрөл	аж ахуйн нэгжийн дундаж үнэ, төг/кг	2016.05.18-ны махны зах зээлийн дундаж үнэ, төг/кг	2016 онд нөөцөлсөн махборлуулах үнэ, төг/кг	Зах зээлийн дундаж үнэ ба борлуулах үнийн харьцуулалт, %	100%	
			1	Үхрийн ястай мах	5640	8490	5750		32,3
			2	Хонины ястай мах	4900	7070	5400		23,6
			3	Ямааны мах	4000	5305	4400		17,1
Махны үнэ хамгийн өндөр байдаг 5-р сард махны үнийн өсөлтийг бууруулж, зах зээлийн махны үнээс 17-32 хувийн хямд үнээр хэрэглэгчдэд мах нийлүүлж, үнэ тогтворжуулсан.									
4	Үр дүн 4	Дотоодын мах бэлтгэл, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, ажлын байр шинээр бий болно.	-Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2016 онд 1556,3 тн үхэр, 1494,8 тн хонь, 4688,3 тн адуу, 1216,8 тн ямааны мах тус тус боловсруулсан нь 2015 оныхтой харьцуулахад адуу, өлөн гэдэс, хиаман төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 26-40 хувиар өссөн бол үхэр, хонь, ямааны махны үйлдвэрлэл 45,6-56 хувиар тус тус буурсан байна.					90%	
			-Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2016 онд мал төхөөрөх, мах боловсруулах дараах үйлдвэрүүд шинээр ашиглалтад орж, 200 ажлын байрыг бий болгосон байна. Үүнд:						
			№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Хүчин чадал			
			1	“Жаргалант шанд” ХХК	Ховд	500 бог, 100 бод			
			2	“Жаргалант мах импекс” ХХК	Орхон	100 бог, 20 бод			
			3	“Мах март” ХХК	Баянхонгор	500 бог, 50 бод			
			4	“Хүрийн Овоо” ХХК	Говь-Алтай	1000 бог, 200 бод			
			5	“Алтайн сүрлэг нуруу” ХХК	Говь-Алтай	250 бог, 100 бод			
			6	“Баяндэлгэр хүнс” ХХК	Төв/Баяндэлгэр	100 бог, 50 бод			
7	“Саян-Уул” ХХК	Улаанбаатар	300 бог, 100 бод						